210602	Тавилга	382,500.00	129,540.00	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00	382,500.00	0.00
210604	Урсгал засвар	23,927,000.00	14,020,300.00	19,527,300.00	13,969,681.29
2107	Томилолт, зочны зардал	8,573,300.00	5,869,300.00	8,473,300.00	7,711,500.00
210702	Дотоод албан томилолт	8,573,300.00	5,869,300.00	1,400,000.00	835,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,966,300.00	14,022,200.00	29,359,300.00	16,874,678.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,739,100.00	4,171,862.00	25,431,200.00	14,072,146.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	651,400.00	651,400.00	2,102,300.00	2,027,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	539,100.00	225,790.00	539,100.00	539,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295,700.00	177,330.00	295,700.00	25,500.00

**Дөрвөлжин сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,600.00	14,800.00	88,600.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,403,400.00	8,566,068.00	203,400.00	0.00
210807	Газрын төлбөр	188,300.00	169,950.00	188,300.00	60,732.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,700.00	45,000.00	60,700.00	45,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	0.00	450,000.00	104,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,068,200.00	24,094,440.00	94,808,700.00	58,686,413.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,721,300.00	16,535,040.00	72,983,300.00	38,631,708.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,346,900.00	7,559,400.00	21,825,400.00	20,054,705.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,605,000.00	6,403,283.00	36,209,700.00	36,190,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,605,000.00	6,403,283.00	36,209,700.00	36,190,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,907,900.00	1,706,183.00	13,020,700.00	13,020,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,197,100.00	4,197,100.00	22,029,000.00	22,029,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	1,160,000.00	1,141,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	198,684,000.00	65,155,246.79	243,801,800.00	56,946,283.00
2200	Дотоод эх үүсвэрээр	198,684,000.00	65,155,246.79	243,801,800.00	56,946,283.00
223001	Бусад хөрөнгө	198,684,000.00	65,155,246.79	243,801,800.00	56,946,283.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	55,303,700.00	26,068,126.00	125,000,000.00	124,674,773.00
230001	Эргэж төлөгдөх зээл	55,303,700.00	26,068,126.00	125,000,000.00	124,674,773.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,258,827,800.00	1,927,145,145.92	2,552,322,900.00	2,371,640,327.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,209,666,600.00	1,121,501,749.94	1,199,716,800.00	1,197,551,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,209,666,600.00	1,121,501,749.94	1,199,716,800.00	1,197,551,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	817,948,800.00	773,068,528.98	941,131,500.00	1,064,539,034.00
122005	Орон нутгийн төсвөөс	697,591,600.00	680,898,781.98	737,330,000.00	860,737,700.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	120,357,200.00	92,169,747.00	203,801,500.00	203,801,334.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,326,800.00	18,848,940.00	22,326,800.00	7,921,820.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,326,800.00	18,848,940.00	22,326,800.00	7,921,820.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	208,885,600.00	13,725,927.00	389,147,800.00	101,628,473.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	841,100.00	11,225,927.00	83,631,600.00	101,628,473.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,500,000.00	0.00	0.00
120004 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	208,044,500.00	0.00	305,516,200.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	66,696,426.67	0.00	81,368,727.88
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	81,368,727.88	0.00	197,963,200.69
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	29.00	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	6.00	6.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	6.00	6.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	108.00	108.00	108.00	108.00
620001	Удирдах ажилтан	13.00	13.00	13.00	13.00
620002	Гүйцэтгэх ажилтан	53.00	53.00	53.00	53.00

Дөрвөлжин сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

620003	Үйлчлэх ажилтан	38.00	38.00	38.00	38.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	4.00	4.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	367.00	367.00	367.00	367.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	227.00	227.00	227.00	227.00
630001	Төрийн өмчит ЕБС	227.00	227.00	227.00	227.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	140.00	140.00	140.00	140.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	140.00	140.00	140.00	140.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	108.00	108.00	108.00	108.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00	9.00	9.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	56.00	56.00	56.00	56.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5.00	5.00	5.00	5.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19.00	19.00	19.00	19.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00	7.00	7.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00	4.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	8.00	8.00	8.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,810,248.00	207,885,263.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,810,248.00	207,270,463.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,930,715.00	150,073,681.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,152,642.00	45,313,765.28
210101	Үндсэн цалин	6,200,000.00	31,185,939.00
210104	Урамшуулал	675,092.00	14,127,826.28
210105	Гэрээт ажлын хөлс	2,277,550.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	8,091,747.72
210201	Тэтгэврийн даатгал	0.00	8,091,747.72
2104	Хангамж, бараа материалын зардал	289,500.00	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	315,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	289,500.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	885,000.00
2105	Нормативт зардал	20,706,504.00	65,048,798.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,706,504.00	60,780,244.00
210502	Хоол, хүнс	0.00	4,268,554.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	580,000.00	17,000,000.00
210604	Урсгал засвар	580,000.00	17,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	249,900.00	1,091,800.00
210702	Дотоод албан томилолт	249,900.00	1,091,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,254,869.00	2,585,570.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,254,869.00	2,424,770.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	160,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	697,300.00	9,742,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	697,300.00	7,330,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	2,411,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,197,822.00	45,898,186.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,197,822.00	45,898,186.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,197,822.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	8,850,048.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	4,953,138.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	32,095,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,681,711.00	11,298,596.36
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	11,298,596.36
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	4,681,711.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	614,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	614,800.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	614,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,810,248.00	208,216,363.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,810,248.00	208,216,363.36
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,971,126.00	163,787,882.36
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,839,122.00	44,428,481.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	331,100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дөрвөлжин сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Г.Чулуунбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дөрвөлжин сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 02/41 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:

“Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж нийгмийг соён гэгээрүүлэх;
- Боловсролын чанарыг сайжруулж, "Чадварлаг багш" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах
- Соёл, спортын үйлчилгээг жигд үзүүлэх
- Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж ажиллах
- Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэх
- Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүртээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлэх
- Хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй сум болох
- Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах
- Нийгмийн амар тайван байдлыг ханган, хуулийн салбарыг хөгжүүлэх
- Цэргийн алба хаах насны эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлж, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх
- Эрсдэлгүй, өндөр ашиг шим бүхий хөдөө аж ахуйг хөгжүүлэх
- Дэд бүтцийг сайжруулж, засварын ажлыг чанартай гүйцэтгэх
- Төсөвт байгууллагуудыг тавилга эд хогшил, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна. Энэхүү хяналтын нэгж нь ТШЗ-ийн үйл ажиллагаанд хяналтыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дөрвөлжин сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн хөрөнгийн нийт орлого 3,495.44 сая төгрөгийн 1.5 хувь буюу 52.43 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 39.32 сая төгрөгөөр тус тус тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 403.70 сая төгрөг болж өмнөх оноос 135.07 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 10.6 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 186.9 сая төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн, 0.1 сая төгрөг нь “Шинэ дөрвөлжин” ОНӨААТҮГ-ын, 0.8 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 205.3 сая төгрөг нь Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

Авлага

Авлагын дансны үлдэгдэл 351.10 сая төгрөг болж өмнөх оноос 183.39 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь 2021 онд ковидоор өвчилсөн иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын хэмнэлт буюу тухайн төсвийн жилд ашиглагдаагүй үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулахаар авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

/төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Засаг даргын тамгын газар	2,365,999.00	188,556.00
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.00	1,705,114.00
Эрүүл мэндийн төв	87,071.75	145,480,524.66
Соёлын төв	0.00	0.00
Сум хөгжүүлэх сан	152,323,004.00	204,085,041.00
“Шинэ дөрвөлжин” ОНӨААТҮГ	1,000,000.00	0.00
Ерөнхий боловсролын сургууль	11,208,600.90	1,174,827.38
Хүүхдийн цэцэрлэг	729,103.74	172,000.00
Дүн	167,713,779.39	351,100,949.04

Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 133.03 сая төгрөг болж өмнөх оноос 9.59 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Эрүүл мэндийн төвд Ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц болон аж ахуйн материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,026.34 сая төгрөг болж өмнөх оноос 53.79 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр

Өглөгийн дансны үлдэгдэл 83.55 сая төгрөг болж өмнөх оноос 22.84 сая төгрөгөөр өссөн байна.

/төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Засаг даргын тамгын газар	14,256,786.00	1,705,114.00
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	4,534,332.85	975,596.73
Эрүүл мэндийн төв	7,169,333.00	39,801,136.00
Ерөнхий боловсролын сургууль	1,000,000.00	7,073,099.00
Орон нутгийн хөгжлийн сан	18,400,000.00	0.00
“Шинэ дөрвөлжин” ОНӨААТҮГ	2,378,447.63	7,450,338.61
Соёлын төв	12,969,929.19	17,383,286.28
Хүүхдийн цэцэрлэг	0.00	9,168,123.37
ДҮН	60,708,828.67	83,556,693.99

Цэвэр хөрөнгө

Цэвэр хөрөнгийн дүн 4,830.62 сая төгрөг болж өмнөх оноос 232.22 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна.

Төсвийн шууд захирагчийн илрүүлэлт:

- Дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас сумын постонд гарч байгаа хүмүүсийн хоол өгсөн;
- Түлш халаалтын зардлаас хөрөнгө бэлтгэсэн, гэрэл цахилгааны зардлаас гудамжны гэрэлтүүлгийн шонгийн толгой бэлтгэсэн боловч нотлох үндсэн баримтгүй;
- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлаас сумын постонд гарч байгаа хүмүүсийн хоол өгсөн, зөрүүтэй тайлагнасан;
- Түлш халаалтын зардлаас 8 хүнд мод олгосон боловч тушаалгүй, зарцуулалтын тайлан байхгүй ба нүүрс давхардуулан олгосон
- Гэрэл цахилгааны зардлаас түлш халаалтын зардалд зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулсан;
- Түлш халаалтын хэмнэсэн зардлаас 50 ажилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон;
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын хэмнэсэн зардлаас ХАОАТ-ыг илүү шилжүүлсэн;
- Тээвэр шатахууны зардлын дүнг санхүүгийн тайланд дутуу илэрхийлсэн зэрэг нийт 17.18 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 2,600.95 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт тодотгол хийж 48.63 сая төгрөгөөр бууруулж 2,552.32 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,552.32 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,183.52 сая төгрөгийг урсгал зардалд, 243.80 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 125.00 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 1,199.71 сая төгрөгийг улсын төсвөөс, 737.33 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 22.32 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 203.80 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 83.63 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 305.53 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,197.55 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 860.73 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 7.92 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 203.80 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 101.64 сая төгрөг, нийт 2,371.64 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 185.45 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 101.64 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 17.99 сая төгрөгөөр давсан нь зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдсөнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,186.19 сая төгрөг буюу 85.65 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсон, эргэн төлөгдөх зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгоогүй, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 39.95 сая төгрөгийг сумын төсөвт, 11.29 сая төгрөгийг аймгийн төсөвт, 28.89 сая төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 0.00 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 163.79 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 44.42 сая төгрөгийн, нийт 208.21 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 207.88 сая төгрөгийг зарцуулж, 0.33 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд онцлон үзэх эрсдэлтэй асуудал тусгагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс, 138 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 0 мэдээллийг огт мэдээлээгүй, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Дөрвөлжин сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар хариуцлага тооцуулах албан шаардлага өгөгдөж, биелэлт нь 95.0 хувьтай хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитаар нийт 19.72 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2.54 сая төгрөгийн алдааг залруулж, 17.18 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.1 Залруулсан алдаа

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг нэгтгэхдээ нэгтгэсэн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд өөрийн орлого болон зардлыг зөрүүтэй тайлагнасан алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал: Дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас сумын постонд гарч байгаа хүмүүсийн хоол өгсөн, түлш халаалтын зардлаас хөрөнгө бэлтгэсэн, гэрэл цахилгааны зардлаас гудамжны гэрэлтүүлгийн шонгийн толгой бэлтгэсэн боловч нотлох үндсэн баримтгүй, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлаас сумын постонд гарч байгаа хүмүүсийн хоол өгсөн, зөрүүтэй тайлагнасан, түлш халаалтын зардлаас 8 хүнд мод олгосон боловч тушаалгүй, зарцуулалтын тайлан байхгүй ба нүүрс давхардуулан олгосон, гэрэл цахилгааны зардлаас түлш халаалтын зардалд зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулсан, түлш халаалтын хэмнэсэн зардлаас 50 ажилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын хэмнэсэн зардлаас ХАОАТ-ыг илүү шилжүүлсэн, тээвэр шатахууны зардлын дүнг санхүүгийн тайланд дутуу илэрхийлсэн зэрэг зөрчлүүд байна.

Энэ нь Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7.6. /хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх/, Засгийн Газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дугаар зүйлийн 7.13.7 /энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд/, 8 дугаар зүйлийн 8.4 /Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана/ гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн Аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ЗДТГ	6	29.95	2	17.17	1	3.73	-	0.00	3	9.05
2	Эрүүл мэндийн төв	4	54.08	1	8.71	1	42.35	-	0.00	2	3.02
3	Хүүхдийн цэцэрлэг	2	1.71	-	0.00	1	1.61	-	0.00	1	0.10
4	Ерөнхий боловсролын сургууль	4	101.81	1	91.07	1	5.32	-	0.00	2	5.42
5	“Шинэ дөрвөлжин” ОНӨААТҮГ	1	1.0	1	1.0	-	0.00	-	0.00	-	0.00
6	Төвлөрүүлэн захирагч	9	19.72	1	2.54	-	0.00	-	0.00	8	17.18
Дүн		26	208.27	6	120.49	4	53.01	0	0.00	16	34.77

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Г.ЧУЛУУНБААТАР

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДАГВАСҮРЭН

2022.03.25